**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/54/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn 2024 он | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн :Баян ташаагийн эх Аудит ХХК<br>Захирал: Т.Хоролсүрэн<br>Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга........................................................................................................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
   4.1 Ерөнхий зүйл ..............................................................................................................................
   4.2 Материаллаг байдал ..........................................................................................................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.................................................................................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................................
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..............................................................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..............................................................................
5. Аудитын илрүүлэлт ..........................................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/79

танай__________-ны № __________-т

ЖИНСТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ДУНД
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
М.БИБИШ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Жинст сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Жинст сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Захирлын 2023 оны 09 дүгээр сарын 06-ний өдрийн Б/53 тоот тушаалаар хөгжмийн боловсролын багш Ц.Бат-Өлзий 2 сарын хугацаатай чөлөө олгосон байхад 9 сарын нийгмийн даатгалын тайланд 01 кодоор 550.0 мянган төгрөгөөр

5020294

тайлагнаж 132.0 мянган төгрөгийн шимтгэл төлж, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 132.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Мөн 16,692.0 мянган төгрөгөөр машин тоног төхөөрөмж, 9,090.0 мянган төгрөгөөр тавилга эд хогшил, нийт 25,782.0 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгджээ.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд төсвийн захирагч 6 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 26 арга хэмжээг бүрэн, 6 арга хэмжээг 100 хувь, 4 арга хэмжээг 97.5 хувь, 1 арга хэмжээг 95 хувь, 4 арга хэмжээг 93.8 хувь буюу нийт дүнгээр 97.4 хувиар биелүүлж, биелэлтийг дээд байгууллагат хүргүүлснээр, дээд байгууллагаас 82.6 хувиар дүгнэгдсэн.

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 142,676.1 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 240, 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

### 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **119,650,447.01** | **158,589,932.07** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 69,894,557.01 | 115,148,556.70 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 69,894,557.01 | 115,148,556.70 |
| **3121** | **Төгрөг** | 69,894,557.01 | 115,148,556.70 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 69,894,557.01 | 115,148,556.70 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 49,755,890.00 | 43,441,375.37 |
| **351** | **Түүхий эд материал** | 37,309,100.00 | 34,896,435.37 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 35,584,500.00 | 34,896,435.37 |
| **354** | **Хангамжийн материал** | 12,446,790.00 | 8,544,940.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,062,050.00 | 484,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,357,600.00 | 7,357,600.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,027,140.00 | 702,440.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,843,500,786.52** | **4,744,570,260.05** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,843,500,786.52 | 4,744,570,260.05 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,810,579,702.98 | 4,711,705,676.47 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,782,035,612.57 | 4,782,035,612.57 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -132,284,732.95 | -212,807,936.83 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 173,692,468.95 | 164,015,045.95 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -83,524,968.73 | -78,033,578.72 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 160,278,985.48 | 163,652,621.48 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -91,094,392.34 | -108,632,817.98 |
| 39217 | Ном | 1,476,730.00 | 1,476,730.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 32,921,083.54 | 32,864,583.58 |
| 39301 | Програм хангамж | 765,000.00 | 765,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -491,916.46 | -548,416.42 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 32,648,000.00 | 32,648,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,963,151,233.53** | **4,903,160,192.12** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,963,151,233.53** | **4,903,160,192.12** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,963,151,233.53 | 4,903,160,192.12 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 421,793,425.59 | 421,793,425.59 |
| 51101 | **Өмч: - төрийн** | 421,793,425.59 | 421,793,425.59 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,539,793,984.64 | 4,479,863,653.23 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,539,793,984.64 | 4,539,854,694.64 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -59,991,041.41 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,563,823.30 | 1,503,113.30 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 4,963,151,233.53 | 4,903,160,192.12 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

## 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **847,226,400.00** | **976,078,765.37** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **23,442,000.00** | **13,574,165.37** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 23,442,000.00 | 13,574,165.37 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 704,000.00 | 553,425.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 553,425.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **823,784,400.00** | **962,504,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 646,087,200.00 | 788,763,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 646,087,200.00 | 788,763,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 177,197,200.00 | 173,741,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 177,197,200.00 | 173,741,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **877,551,217.18** | **1,036,069,806.78** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **877,551,217.18** | **1,036,069,806.78** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 846,206,479.91 | 1,002,063,076.78 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 447,809,732.15 | 558,139,374.31 |
| 210101 | Үндсэн цалин | 323,358,121.39 | 392,607,028.91 |
| 210102 | Нэмэгдэл | 89,509,581.53 | 142,820,043.90 |
| 210104 | Урамшуулал | 6,807,758.60 | 22,712,301.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 55,388,579.40 | 70,955,497.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,250,990.25 | 48,094,297.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,482,121.83 | 5,974,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,585,697.21 | 4,829,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 818,355.08 | 1,074,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,251,415.03 | 10,983,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 142,109,679.00 | 171,200,938.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,943,675.00 | 7,569,638.00 |
| 210302 | Түлш, халаалт | 134,446,004.00 | 161,341,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 720,000.00 | 2,290,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,955,250.00 | 23,490,750.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,053,250.00 | 12,375,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 587,500.00 | 2,105,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 675,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 19,314,500.00 | 4,366,700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 3,968,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 38,925,200.00 | 39,858,086.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,358,900.00 | 1,724,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 37,566,300.00 | 38,133,486.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 850,000.00 | 1,525,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 850,000.00 | 1,525,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,222,000.00 | 2,323,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,680,000.00 | 550,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 542,000.00 | 1,773,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 131,946,039.36 | 134,569,631.47 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,491,300.00 | 9,214,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 764,250.00 | 643,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 117,071,791.27 | 124,712,531.47 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 31,344,737.27 | 34,006,730.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,741,900.00 | 33,464,868.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 23,680,500.00 | 28,453,014.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,061,400.00 | 5,011,854.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,602,837.27 | 541,862.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,602,837.27 | 541,862.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-30,324,817.18** | **-59,991,041.41** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-30,324,817.18** | **-59,991,041.41** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

## 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

**/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 421,793,425.59 | 1,563,823.30 | 4,539,793,984.64 | 4,963,151,233.53 |
| D01 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 421,793,425.59 | 1,563,823.30 | 4,539,793,984.64 | 4,963,151,233.53 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 60,710.00 | 60,710.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 421,793,425.59 | 1,563,823.30 | 4,539,854,694.64 | 4,963,211,943.53 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -60,710.00 | 00.00 | -60,710.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -59,991,041.41 | -59,991,041.41 |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 421,793,425.59 | 1,503,113.30 | 4,479,863,653.23 | 4,903,160,192.12 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **824,488,400.00** | **963,058,025.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **704,000.00** | **553,425.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 704,000.00 | 553,425.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 704,000.00 | 553,425.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **823,784,400.00** | **962,504,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 646,087,200.00 | 788,763,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 646,087,200.00 | 788,763,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 177,197,200.00 | 173,741,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 177,197,200.00 | 173,741,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **742,603,842.99** | **903,388,125.31** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **742,603,842.99** | **903,388,125.31** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **712,448,505.72** | **870,048,509.31** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 446,975,097.32 | 561,159,771.31 |
| 210101 | Үндсэн цалин | 322,523,486.56 | 393,627,426.81 |
| 210102 | Нэмэгдэл | 89,509,581.53 | 144,820,043.00 |
| 210104 | Урамшуулал | 6,807,758.60 | 22,712,301.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 55,388,579.40 | 67,935,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,250,990.25 | 46,211,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,482,121.83 | 5,437,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,585,697.21 | 4,349,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 818,355.08 | 1,063,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,251,415.03 | 10,873,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 143,024,679.00 | 171,200,938.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,103,675.00 | 7,437,530.00 |
| 210302 | Түлш, халаалт | 134,446,004.00 | 161,341,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,475,000.00 | 2,422,108.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 36,464,450.00 | 38,461,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 36,464,450.00 | 38,236,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 1,773,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,773,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,359,700.00 | 2,965,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 697,400.00 | 550,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,662,300.00 | 2,415,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,236,000.00 | 26,552,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,243,050.00 | 20,768,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,992,950.00 | 5,784,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **30,155,337.27** | **33,339,616.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,552,500.00 | 32,797,754.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 22,491,100.00 | 27,785,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,061,400.00 | 5,011,854.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,602,837.27 | 541,862.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДУГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,602,837.27 | 541,862.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **81,884,557.01** | **59,669,899.69** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **11,990,000.00** | **14,415,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **11,990,000.00** | **14,415,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 11,990,000.00 | 14,415,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 11,990,000.00 | 14,415,900.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-11,990,000.00** | **-14,415,900.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 69,894,557.01 | 45,253,999.69 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 69,894,557.01 | 115,148,556.70 |

## 2.5.1Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 69 ,894,557.01 | | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,032,407,338.81 | 917,262,163.31 | 115,145,175.50 | 88.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,032,407,338.81 | 917,262,163.31 | 115,145,175.50 | 88.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 980,121,538.81 | 884,464,409.31 | 95,657,129.50 | 90.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 637,432,200.81 | 561,159,771.31 | 76,272,429.50 | 88 |
| 210101 | Үндсэн цалин | 442,961,300.81 | 393,627,426.81 | 49,333,874.00 | 88.9 |
| 210102 | Нэмэгдэл | 170,073,300.00 | 144,820,043.00 | 25,253,257.00 | 85.2 |
| 210104 | Урамшуулал | 24,397,600.00 | 22,712,301.50 | 1,685,298.50 | 93.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 79,679,600.00 | 67,935,100.00 | 11,744,500.00 | 85.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,182,400.00 | 46,211,500.00 | 7,970,900.00 | 85.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,374,300.00 | 5,437,200.00 | 937,100.00 | 85.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,099,400.00 | 4,349,700.00 | 749,700.00 | 85.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,274,800.00 | 1,063,300.00 | 211,500.00 | 83.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,748,700.00 | 10,873,400.00 | 1,875,300.00 | 85.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 171,200,938.00 | 171,200,938.00 | - | 100 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,569,638.00 | 7,569,638.00 | - | 100 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 161,341,300.00 | 161,341,300.00 | - | 100 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,290,000.00 | 2,290,000.00 | - | 100 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 44,412,900.00 | 38,461,400.00 | 5,951,500.00 | 86.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 225,000.00 | -225,000.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 44,412,900.00 | 38,236,400.00 | 6,176,500.00 | 86.1 |
| 210502 | Хоол, хүнс | 1,298,000.00 | 1,773,500.00 | -475,500.00 | 136.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,298,000.00 | 1,773,500.00 | -475,500.00 | 136.6 |
| 210604 | Урсгал засвар | 4,882,900.00 | 2,965,000.00 | 1,917,900.00 | 60.7 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,026,800.00 | 550,000.00 | 476,800.00 | 53.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,856,100.00 | 2,415,000.00 | 1,441,100.00 | 62.6 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 41,215,000.00 | 40,968,700.00 | 246,300.00 | 99.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,430,900.00 | 35,184,600.00 | 246,300.00 | 99.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,784,100.00 | 5,784,100.00 | - | 100 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 52,285,800.00 | 32,797,754.00 | 19,488,046.00 | 62.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 52,285,800.00 | 32,797,754.00 | 19,488,046.00 | 62.7 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 47,272,900.00 | 27,785,900.00 | 19,487,000.00 | 58.8 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж,урамшуулал | 5,012,900.00 | 5,011,854.00 | 1,046.00 | 100 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,032,407,338.81 | 963,058,025.00 | 69,349,313.81 | 93.3 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 788,763,300.00 | 788,763,300.00 | - | 100 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 788,763,300.00 | 788,763,300.00 | - | 100 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 174,283,162.00 | 173,741,300.00 | 541,862.00 | 99.7 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 174,283,162.00 | 173,741,300.00 | 541,862.00 | 99.7 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,253,400.00 | 553,425.00 | 699,975.00 | 44.2 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1,253,400.00 | 553,425.00 | 699,975.00 | 44.2 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос | 68,107,476.81 | - | 68,107,476.81 | - |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | санхүүжих | | | | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 69,894,557.01 | | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 115,148,556.70 | | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жинст сумын Ерөнхий боловсролын дунд сургууль нь боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд суралцагчдын мэдлэг чадвар, багшийн хөгжлийг дэмжих, хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэн ажиллах чиг үүрэгтэй байгууллага юм.

Тус байгууллага нь дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

Суралцагсдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс шинээр мөрдөгдөж эхэлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Жинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59,991.0 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 69,894.5 | 115,148.5 | 45,254.0 |
| Бараа материал | 49,755.0 | 43,441.4 | -6,313.6 |
| Үндсэн хөрөнгө анхны өртөг | 5,150,896.7 | 5,144,593.0 | (6,303.7) |
| Хуримтлагдсан элэгдэл | (307,396.0) | (400,022.7) | (92,626.7) |
| Нийт хөрөнгө | 4,963,151.2 | 4,903,160.2 | -59,991.0 |
| Засгийн газрын хувь оролцоо | 421,793.4 | 421,793.4 | 0 |
| Хуримтлагдсан үр дүн | 4,539,794.0 | 4,479,863.6 | -59,930.3 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,563.8 | 1,503.1 | -60.7 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 4,843,500.8 | 4,744,570.3 | -59,991.0 |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, данс байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 115,148.5 мянган төгрөг болж 45,254.0 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээр санхүүжсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 43,441.4 мянган төгрөг болж, 6,313.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 7,549.8 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг өмнөх оны үлдэгдлээс, тусгай зориулалтын материал данснаас жилийн эцсийн тооллогын үр дүнгээр захирлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/49 тоот тушаалаар 3,972.7 мянган төгрөгийн бараа материалыг актлалснаас голлон шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,744,570.3 мянган төгрөг болж, 59,991.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил данснуудад 9,866.2 мянган төгрөгийн хандивын хөрөнгийг БСШУЯ, 15,915.8 төгрөгийн худалдан авалтыг хийсэн, мөн 2 данснаас 32,085.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хасалт хийсэн, тайлант онд 124,712.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулснаас тус тус шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 128,852.4 мянган төгрөг буюу 15.2 хувиар өсөж, нийт зардал өмнөх оноос 158,518.6 мянган төгрөг ба 18.1 хувиар нэмэгдэж тайлант оны үр дүн 59,991.0 мянган төгрөгөөр алдагдалтай ажилласан нь хуримтлагдсан үр дүн 59,930.3 мянган төгрөгөөр буурсанд нөлөөлжээ.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн шууд захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,120,390.3 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийг 206,679.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 331,627.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 32,396.7 мянган



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

төгрөгөөр бууруулж баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс буурсан байгаа нь төсвийг бодит бус, буруу төсөвлөж байгаатай холбоотой байна.

Дээрх баталсан төсвөөс санхүүжилтийг бүрэн олгож, төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд 115,148.5 мянган төгрөгийг улсын төсөвт, 541.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан тус тус төвлөрүүлсэн нь улсын төсвөөс санхүүжсэн цалин, урсгал шилжүүлэг, хоол хүнсний зардлуудыг, орон нутгийн төсвөөс санхүүжих гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, эд хогшил урсгал засварын зардлуудыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн шууд захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,120,390.3 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийг 206,679.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 331,627.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 32,396.7 мянган төгрөгөөр бууруулж баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс буурсан байгаа нь төсвийг бодит бус, буруу төсөвлөж байгаатай холбоотой байна.

Дээрх баталсан төсвөөс санхүүжилтийг бүрэн олгож, цалин, нийгмийн даатгалын зардлуудад 629,094.8 мянган, нормативт зардалд 38,236.4 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 40,968.7 мянган, бусад урсгал шилжүүлэгийн зардалд 32,797.7 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 40,968.7 мянган, нийт 744,759.8 мянган төгрөгийг зарцуулж, 115,148.5 мянган төгрөгийг үлдэглэлтэй байна.

Төсвийн улсын төсвийн нийт зардлын гүйцэтгэл 917,262.2 мянган төгрөг буюу 88.8 хувьтай байгаа нь төсвийг хэмнэн дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

| Д/д | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71601 | Боловсролын сургалт | 1,032,407.3 | 917,262.2 | 115,145.2 | 88.8 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 903,441.9 | 816,529.3 | 86,912.6 | 90.4 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 79,679.6 | 67,935.1 | 11,744.5 | 85.3 |
| 83112 | Хөтөлбөр төслийн дотоод урсгал | 52,285.8 | 32,797.8 | 19,488.0 | 62.7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсөл, арга хэмжээнд 66,261.8 мянган төгрөгийг тусгаж баталснаас, гүйцэтгэлээр 99,739.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хүүхдэд ээлтэй орчин төсөл хөтөлбөрийн хүрээнд 14,415.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авалтын аргаар, харьцуулалтын тендерийн аргаар үдийн цай хөтөлбөрийн 66,261.8 мянган төгрөгийг, харин бусад хангамж бичиг хэргийн 19,061.4 мянган төгрөгийн бараа материалыг шууд худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Жинст сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн хооронд Баян ташаагийн эх аудит ХХК-ийн аудитор Б.Хандсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Хоролсүрэн, аудитын менежер М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 863,075.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,630.8 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,041.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шалгагдагч байгууллага нь нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхгүй арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд цалин, нийгмийн даатгалын зардлуудад 88,016.9 мянган, нормативт зардалд 6,176.5 мянган, бусад урсгал шилжүүлэгийн зардалд 19,488.0 мянган төгрөгийн зарлуудыг хэмнэн улсын төсөвт 115,148.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн, хэмнэж ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, тушаал шийдвэрийг бүрэн мэдээлж, таван саяас дээш 184,050.5 мянган төгрөгийн зарлагын 10 гүйлгээнээс 2 гүйлгээний 46,195.7 мянган төгрөгийг мэдээлээгүй, 828,188.5 мянган төгрөгийн орлогын 35 гүйлгээг бүрэн мэдээлсэн ба хуулийн хэрэгжилт 95.4 хувьтай байна.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд нийт 2,518,901.4 мянган төгрөгийн 120 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах албан шаардлага хүргүүлэв

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгээгүй.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар тогтоосон 2,397.8 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 14,171.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 8,035.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн биелүүлсэн байна.

Өмнөх онд өгсөн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдан гарсан, 3263.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг барагдуулаагүй тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 5 | 5,660.8 | 4 | 2,397.8 | 42.4 |
| Албан шаардлага | 2 | 14,171.4 | 2 | 14,171.4 | 100 |
| Зөвлөмж | 2 | 8,035.0 | 2 | 8,035.0 | 100 |
| Нийт дүн | 9 | 27,867.2 | 9 | 24,607.2 | 88.3 |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 132.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг илрүүлж, зөрчлийг нөхөн төлүүлэх 132.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 132.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,041.5 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**5.1.1 Төлбөрийн акт**

Захирлын 2023 оны 09 дүгээр сарын 06-ний өдрийн Б/53 тоот тушаалаар хөгжмийн боловсролын багш Ц.Бат-Өлзийд 2 сарын хугацаатай чөлөө олгосон байхад 9 сарын нийгмийн даатгалын тайланд 01 кодоор 550.0 мянган төгрөгөөр тайлагнаж 132.0 мянган төгрөгийн шимтгэл төлж, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 132.0 мянган /Нэг зуун гучин хоёр мянган/ төгрөгөөр илүү тайлагнасан.

Энэ ньТөсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн, аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Илүү тайлагнасан нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 132.0 мянган /Нэг зуун гуяин хоёр мянган/ төгрөгийг Төсвийн шууд захирагчаар албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, тушаал шийдвэрийг бүрэн мэдээлж, таван саяас дээш 184,050.5 мянган төгрөгийн зарлагын 10 гүйлгээнээс 2 гүйлгээний 46,195.7 мянган төгрөгийг мэдээлээгүй, 828,188.5 мянган төгрөгийн орлогын 35 гүйлгээг бүрэн мэдээлсэн ба хуулийн хэрэгжилт 95.4 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулаагүй, өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд буруу илэрхийлсэн | 1 | 132.0 | | | 1 | 132.0 | | | | | | |
| Дүн | 1 | 132.0 | 0 | 0 | 1 | 132.0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Захирлын 2023 оны 09 дүгээр сарын 06-ний өдрийн Б/53 тоот тушаалаар хөгжмийн боловсролын багш Ц.БатӨлзий 2 сарын хугацаатай чөлөө олгосон байхад 9 сарын нийгмийн даатгалын тайланд 01 кодоор 550.0 мянган төгрөгөөр тайлагнаж 132.0 мянган төгрөгийн шимтгэл төлж, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 132.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. | 1 | 132.0 | 1 | 132.0 | | | | |
| Дүн | 1 | 132.0 | 1 | 132.0 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 46,195.7 мянган төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна. | 1 | 46,195.7 | | | | | | | 1 | 46,195.7 | | |
| | 1 | 46,195.7 | | | | | | | 1 | 46,195.7 | | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ